

Шугаман замаар явдаг хүний хувьд ойлгоход хэцүү нэг юм

“Хайрт ах Паул маань
өгөгдсөн мэргэн ухааныхаа
дагуу та нарт бичсэнчлэн
бидний Эзэний тэвчээрийг
аврал хэмээн тооц.
Түүний бүх захидалд
эдгээрийн талаар бичсэн юм.



Захидлуудад нь ойлгоход хэцүү зарим зүйл байдаг бөгөөд юу ч мэдэхгүй, туйлбаргүйчүүд Бичвэрийн бусад зүйлсийг гуйвуулдаг шигээ тэдгээрийг ч мушгин гуйвуулж өөрсдийгөө сүйрүүлдэг.”

2 Петр 3:15-16

Паулыг онцгой сайн мэдээтэй нь хамт хүлээн зөвшөөрөхөд хүргэх гэж Их Эзэн Петрийг хэрхэн бэлдсэн тухай бид өмнөх нийтлэлд авч үзсэн. Дээрх ишлэлээс харахад Петр Паулыг хүлээн аваад зогсохгүй, харин их үнэлж, Ертөнцийн Эзэний мэргэн ухааныг авсан хүнд тооцов. Паулын захидлуудыг Петр Их Эзэний эрх мэдлийг тээдэг Бичвэр гэж харсан юм. Эдгээрийн дундаас Петр ялангуяа “та нарт” буюу «Еврейчүүдэд» бичсэн захидлыг онцолсон.


Үүний дараахан Петр Паулын “бүх захидал” буюу бусад захидлыг нь дурддаг. Эдгээр захидалд “ойлгоход хэцүү зарим зүйл байдаг” гэсэн. Энэ үгнээс ч харахад Паул тунхагладаг сайн мэдээгээ Петрээр заалгаагүй нь илэрхий. Яг юу нь ойлгоход бэрх байгааг Петр хэлээгүй ч гэсэн бид тааж болно. Энэ нийтлэлд бид Петрийн хэлсэн байж болох нэг ишлэлийг авч үзээд, хоёр сайн мэдээний хоорондох бас нэгэн ялгааг олох болно.



Шугаман замаар явдаг хүмүүс

Петрийн хариуцаж авсан сайн мэдээг базаж хэлэхэд, «Хуучин гэрээ»-ний олон бичвэрт Израилд амласан амлалтын биелэл болох Хаант улс байгуулагдах нь дөхөж ирсэн байна. Ертөнцийн Эзэн Машиах Хааныг ч илгээсэн. Есүс гэдэг тэр Хааныг тэрлэгч этгээд алсан ч Ертөнцийн Эзэн үхлээс амилуулан үнэхээр Өөрийн илгээсэн Аврагч мөн болохыг баталсан. Иймд Ертөнцийн Эзэнтэй эрт дээр үед гэрээ хийсэн ард түмний гишүүдийн хувьд Түүний илгээсэн Есүс тэр Хаан мөн гэдэгт итгээд дагалдагч нь болсныг батлах сайн үйлс хий. Юуны өмнө усан баптисм хүртээгээд Түүний энэ дэлхий дээр байхдаа заасан бүхнийг дагах ёстой.

Энэ нь «Хуучин гэрээ»-ний бичвэрүүдтэй шууд авцалдах бөгөөд үргэлжлэл нь болох нь тодорхой. Израилчууд бол нэг ёсондоо шугаман замаар явдаг мэт алхам алхмаар урагшилдаг хүмүүс. Эхлээд тэд Мосегээс Хуулийг хүлээн авч, олон зуун жилийн турш биелүүлэхийг хичээгээд байж байгаад эцэст нь **бүтэхгүй** гэж мэдлээ. Давид хаанд Их Эзэн сөнөшгүй хаант улсыг амласан ч Давид хааны хаант улс сөнөсөн. «Хуучин гэрээ»-нд тэмдэглэсэн урт удаан түүхийн эцэст Есүс ирж, амлагдсан Хаант улсын дөхөөд ирснийг зарлахад Петр зэрэг зарим иудейчүүд Түүнийг амласан Машиах Аврагч гэж таньсан.





Гэвч ихэнх иудейчүүд тэр мэдээнд итгээгүй учраас Хаант улс ирэх нь хойшлогдсон. Энэ нь Мосегийн үед болсон явдалтай төстэй. Тэр үеийн израилчууд яг амлагдсан нутагт орох гэж байхад дийлэнх нь итгэлгүй ханлага гаргасны төлөө шийтгүүлж, олон жилийн турш цөлд тэнүүчилдэг болсон. Цөөн хэдэн үнэнч итгэлтэй хүмүүс яалт ч үгүй хамт цөлөөр явахаас өөр аргагүй. Үүнчлэн Есүст итгэсэн хэдэн хүн өмнөх үеийн итгэлийн баатрууд шиг авсан амлалтынхаа биеллийг тэвчээртэйгээр хүлээх хэрэгтэй болсон. Тэд одоо ч Есүсийг эргэн ирж амласан Хаант улсыг байгуулна гэж хүлээгээд байна.

Ирэхээр нь үнэнчээр үлдсэн израилынхан үхлээс амилж, энэ дэлхийн бүх үндэстнүүдийг захирах хаад болж, тэдэнд Ертөнцийн Эзэний тухай зааж, **хооронд нь** зуучлах тахилчаар үйлчилнэ. Улмаар, амласан бүхнийг хүртэн авч, үнэн сайхан амьдрах болно.

Үүнээс цааш бодох шаардлага Израилын итгэгчдэд байхгүй. Тэр Хаант улсад орох нь л хамгийн чухал юм.

Мосегийн үеийн израилчууд олон жилийн турш цөлд тэнүүчилж байхдаа амлагдсан нутагт орохыг л хүлээдэг байсан шиг Христэд итгэгч израилынхан Хаант улсад орохыг л боддог. Тэд алхам алхмаар л явдаг.



Христийн Бие шугаман замаар явдаггүй

Тэгвэл энэ бүхэнтэй Паулын бүх үндэстэнд зарласан сайн мэдээг харьцуулж үзээрэй. Тухайлбал: Христ нэгмөсөн




үхээд үхлээс амилахдаа гэм буруугаас үүрд хагацаж, цоо шинэ бүтээлийг эхлүүлсэн. Энэ явдалд Ертөнцийн Эзэн биднийг нэгдүүлж, одоо ч Түүн шиг ямар ч гэм буруугүй цоо шинэ бүтээл болсонд тооцон (“зөвтгөл”), биднийг дайснаа гэж харахаа больж гэр бүлдээ ч оруулсан (“эвлэрэл”). Энэ гайхалтай сайхан мэдээнд итгэсэн хүмүүс “Христийн Бие”-ийн гишүүн болж, Түүнтэй бодол санаа, зан чанараар улам адил болоод зогсохгүй тэнгэр өөд одсон Түүнийг ирээдүйд тийш даган, тэнгэрийн дээрх улсад үйлчлэх дуудлагатай. Тэр хүртэл бид харснаараа биш, итгэлээр алхах ёстой.

Энэ сайн мэдээ Петрийн заадаг зүйлсээс эрс өөр биш гэж үү? Тэгвэл зарим зүйл нь түүнд ойлгоход хэцүү санагдсанд гайхах юмгүй. Яахав, зөвтгөл нь Ертөнцийн Эзэний бас нэгэн “инээдтэй” гэмээр үгэнд итгэсэн Абрахамын үлгэр дуурайлал дээр үндэслэсэн учраас (Ром 4) Петр зөвтгөлийг тодорхой хэмжээгээр ойлгосон байх. Эвлэрэл нь Адамын зөрчлийн бий болгосон дайсгалыг үгүй хийн эргүүлэх учраас Петр эвлэрлийг мөн төсөөлж чадсан биз ээ.

Гэхдээ үнэхээр ойлгоход хэцүү нэг зүйл байна. Юу гэвэл, Христийн Бие шугаман замаар явдаггүй. Бид Израилын хийх ёстой олон алхмын дээгүүр харайж, нисдэг мэт. Биднийг Паул “үеийн төгсгөл тохиож буй” хүмүүс гэсэн (1 Коринт 10:11). Энэ үг үнэхээр ойлгоход хэцүү учраас орчуулагч нар ихэвчлэн зөв орчуулж чадаагүй. Грек бичвэрт Паул үгчлэн орчуулахаар “**эон үеүдийн (G165) төгсгөлүүд (G5056) бидэнд хүрч ирсэн (G2658)**” гэжээ. Энэ юу гэсэн үг вэ?



Библид “үе” гэж орчуулж болох хэд хэдэн янзын грек үг байдаг учраас G165-н кодтой “айон” гэсэн үгийг тодруулж гаргахын тулд бид “эон үе” гэж орчуулдаг. Энэ үг маш урт удаан хугацааг хэлдэг бөгөөд монгол геологчид “эон” гэсэн грек үгийг яг тийм утгаар хэрэглэдэг. Библид энэ үгийг хэд хэдэн янзаар орчуулдаг учраас утга нь орчин үеийн уншигч нарт тодорхойгүй байхаас өөр аргагүй.¹ Гэхдээ «Шинэ гэрээ»-г грек эх хэлээр нь, эсвэл конкордант аргаар² орчуулсан орчуулгаар судалбал Паулын дээрх үгийг ойлгож авах боломжтой.



- 1 Эон үеүдийн тухай ойлголт авахын тулд “мөнх гэсэн ойлголт”-ийн тухай цувралыг маань үзнэ үү!
- 2 Конкордант аргаар орчуулахад нэг грек үгийг аль болохоор ганц монгол үгээр орчуулж, тэр монгол үгээр өөр грек үгийг орчуулахгүй. Жишээлбэл, ихэнх орчуулганд “айон” гэсэн грек үгийг “мөнх, үе, дэлхий” гээд янз бүрээр орчуулдаг учраас үнэн утга нь бүрхэг болсон. Зөв ойлголт авахын тулд “айон” гэсэн үгийг бүх тохиолдолд “эон үе” гэх зэрэг ганц үг хэллэгээр орчуулах ёстой.



Бидэнд ирсэн “эон үеүдийн төгсгөлүүд”

Паул “эон үеүдийн төгсгөлүүд бидэнд хүрч ирсэн” гэж бичсэн билээ. Тэгвэл «Шинэ гэрээ»-ний бичвэрүүдэд ирээдүйн ядаж хоёр “эон үеүд” (Эфэс 2:7, АБ: “үеүд”) ба тус тусын төгсгөлийн тухай гардаг (дээрх зургыг үзнэ үү). “Төгсгөл” (G5056) гэж орчуулсан үг юмны “эцэс”, эсвэл “үр дүн” буюу “зорьж байсан зорилго бүтсэн амжилт”-ыг хэлнэ.

Ирээдүйн хоёр эон үеийг тоочиход:

1. Айсуй эон нь удахгүй байгуулагдах Хаант улсын эон үе-ийг хэлнэ. Энэ нь мянган жилийн хугацаатай. Төгсгөлд нь энэ хуучин бүтээл үгүй болж, Ертөнцийн Эзэн шинэ тэнгэр, шинэ газрыг бүтээх болно (Илчлэл 20:4,11; 21:1). Шинэ бүтээлд зөвт байдал оршино (2 Петр 3:13 – Петр эон үеүдийн тухай мэдэлгүй яахав).



2. Шинэ бүтээлийн эон үе. “Эонүүдийн эон” гэдэг энэ хамгаас сайхан эон үеийн турш Ертөнцийн Эзэн “бүх юмсыг шинэ болгож байна” (Илчлэл 21:5). “Төгсгөл”-д (G5056) нь үхэл “хүчингүй болох”-од үхэшгүй амьдрал ноёрхох болно. Тэр үед Ертөнцийн Эзэн “бүгдэд бүх юм болно” (1 Коринт 15:24,26,28).



Эдгээр ”зон үеүдийн төгсгөлүүд” Паулын бичсэнээр одоо ч “бидэнд хүрч ирсэн” гэнэ! Израил алхам алхмаар явж явж, Есүсийг эргэж ирэхэд амласан Хаант улсад орж, явж явж мянган жилийн дараа шинэ бүтээлд орж, хэдэн мянган жилийн турш бүү мэд яваад яваад эцэст нь л Ертөнцийн Эзэний “бүгдэд бүх юм болох” тэр төгсгөлд хүрэх болно.

Харин Христийн Биеийнхэн бид тэдэн шиг алхам алхмаар явдаггүй. Зүйрлэвээс, Израилынхан алхам алхмаар өндөр уулын оргил өөд авираад авираад байхад биднийг нисдэг тэрэг шууд л, нэгмөсөн



тэдгээр уулын оргил дээр аваачсан байна. Бид зон үеүдийн төгсгөлүүдэд хүрч очих шаардлагагүй – харин ч эсрэгээр нь, төгсгөл буюу бүтсэн амжилтууд нь бидэн дээр хүрч ирсэн байна! Энэ чинь “галзуу” гэмээр үг биш үү? Энэ чинь ойлгоход хэцүү биш гэж үү?

Шинэ бүтээл бидэнд ирсэн байна

Тайлбарлаваас, Хаант улсын зон үеийн төгсгөл болох шинэ бүтээл бидэнд ирсэн байна. Тухайлбал: **“Одооноос эхлэн бид хэнийг ч махбодын дагуу үзэхгүй. Христийг ч бид махбодын дагуу мэддэг байсан бол Түүнийг одоо тэр байдлаар мэдэхээ больсон. Иймээс хүн Христ дотор**



байвал шинэ бүтээл мөн. Харагтун, хуучин нь өнгөрөн одож, шинэ нь бий болсон байна!” (2 Коринт 5:16-17; МО. “Христ дотор” гэдэг нь Христийн Биеийн гишүүдийг хэлэх билээ. “Өнгөрөн одох” гэсэн грек үгийг Илчлэл 21:1-т анхны тэнгэр, анхны газар хоёрт ч хэрэглэсэн байна).

Бидний одоо ч сүнсээр шинээр бүтээгдсэн байгаа байдлыг дүрслэхээр Паул ирээдүйд бүтээгдэх шинэ тэнгэр, шинэ газрыг дүрслэл болгон ашигласан. Бид одоо ч шинэ бүтээлийн зөвт байдалд оршдог болсон. Иймд бид одоо ч “шинэ амийн дотор явах”-ад дуудагдсан (Ром 6:4). Ертөнцийн Эзэн биднийг одоо ч сүнсний хувьд “харанхуйн эрх мэдлээс авраад, хайрт Хүүгийнхээ хаанчлалд шилжүүлсэн юм” (Холоссай 1:13)³. Бид Сатаны эрхшээлээс гарсан бөгөөд түүний заль мэхэнд хууртагдах албагүй болсон. Үүний тулд бид “**өөрсдийгөө энэ эон үед тааруулан нийцүүлэх%тохиргох**” хэрэггүй, харин Ертөнцийн Эзэний үгээр “оюун санаагаа шинэчилснээр өөрчлөгдөх” хэрэгтэй (Ром 12:2; МО). Иймд Паул биднийг Ертөнцийн Эзэнийг таньж мэдэх мэдлэгээр өсөөсэй гэж гуйдаг байсан (Колоссай 1:10)

Энэ шинэ бүтээл, шинэ хүн төрөлхтөний үнэнд Израил хүрэх болоогүй. Тэдэнд зөвтгөлийн тухай мэдээ ч очоогүй байна. Тийм учраас тэд гэмийнхээ төлөө уучлал

3 Мянган жилийн хаант улсад Их Эзэн Есүс Хүний Хүүгийн хувьд хаанчилна (Даниел 7:13-14; Матай 16:27; 19:28; 24:30; 25:31; 26:64). Харин шинэ бүтээлд Тэрээр Ертөнцийн Эзэний Хүүгийн хувьд хаанчлах болно. Иймд “Ертөнцийн Эзэний Хүүгийн хаанчлал” Түүний шинэ тэнгэрт, шинэ дэлхийд хаанчлах хаанчлалыг хэлнэ.



гуйх ёстой хэвээр бөгөөд авсан уучлалаа цуцлуулахгүйн тулд биеэ зөв авч явах ёстой. Улмаар, тэд “дахин төрөх” ёстой. Төрөх явдал ч тэднийг хуучин бүтээлд хамааруулах билээ. Израилчууд ирээдүйн мянган жилд хуучны энэ бүтээлд амьдарсаар байх болно гэсэн үг. Мянган жилийн дараа л тэд зөвт байдал орших шинэ бүтээлийн эон үед ороход л зөвтгөлийн тухай сурах цаг нь ирнэ. Шинэ бүтээлийн газар дэлхийд Ертөнцийн Эзэн Өөрөө хүмүүсийн дунд нутаглах учраас сүмийн өргөө ч байхгүй байх болно (Илчлэл 21:3,22).

Үхлийн эцэс бидэнд ирсэн байна

Бидэнд шинэ бүтээлийн эон үеийн төгсгөл хүртэл хүрч ирсэн байна. Үхэшгүй амьдрал ноёрхож, Ертөнцийн Эзэн “бүгдэд бүх юм болно” гэсэн зорилго нь бидний хувьд ямар ч байсан маш ойрхон байна. Христ дотор буй биднийг Ертөнцийн Эзэн Христтэй хамт үхэгсдээс амилсанд тооцдог. Тэргүүнийхээ үхэшгүй амийг бид нэг ёсондоо хуваалцдаг гэсэн үг. Үхэшгүй амь гэдэг нь “өөрийн дотроо” хэзээ ч бөхөшгүй амьтай байхыг хэлнэ (Иохан 5:26). Есүс Христ биднийг Өөртөө тэнгэр өөд шүүрч авахад бид тийм үхэшгүй биетэй болно.

Түүний Үг баттай учраас бид энэ биеэрээ үхсэн ч Үхэл гэдэг дайсанд автсаар байх боломжгүй, харин ч эсрэгээр нь Үхэл бидний хөлийн гишгүүр болох нь лавтай (Үйлс 2:24,35). Энэ утгаар үхлийг одоо ч бидний хувьд хүчингүй болсонд тооцож болно. Харин израилчууд ирээдүйн эон үеүдийн турш амиа амийн модоор тэжээлгэх болно (Илчлэл 2:7; 22:2,14).



Ертөнцийн Эзэнд ойртохын хувьд израилчууд тэргүүн тахилч нь болсон Христийн цусаар ариутгагдсан учраас сүмийн өргөөний хамгийн ариун газарт нэвтрэн орох мэт Ертөнцийн Эзэний



Оршихуйд орох замтай болсон (Еврей 10:19). Тийш орох нь мөргөн хүндэтгэл өргөх зорилготой. Энэ үнэнийг мэдсэн ч гэсэн зориуд гэм хийсэн хүн Христийн өргөлийг үл тоосны төлөө хатуугаар шийтгүүлж, тийш орох эрхээ ч хасуулах болно (Еврей 10:26-29).

Харин Христийн Биед хамрагдах бидэнтэй Ертөнцийн Эзэн өнөөдөр ч бүрэн эвлэрсэн бөгөөд бид мөн Түүнтэй эвлэрсгээсэн. Иймд бид Христтэй нэгдсний ачаар ямар ч тахилчаар дамжилгүйгээр шууд л хайртай “Эцэг рүү нэвтрэх эрхтэй болжээ” (Эфэс 2:18, МО). Бид Түүнийг мэдээж бас хүндэлдэг. Гэхдээ хүүхэд Аав дээрээ гүйж очдог шиг бид юунд ч санаа зоволгүйгээр Түүнд ямар ч шалтгаанаар хамаагүй чөлөөтэй гүйн очих эрхтэй. Христийн дотор байгаа биднийг Ер бусын Аав “миний таалдаг хайрт хүү” гэж угтаж авах нь гарцаагүйг бид мэднэ (Матай 3:17).

Ер бусын Эцэгээ таньж мэдэх тусам Тэрээр бидэнд “улам илүү их юм болж байна”. Эон үеүдийн төгсгөлд Ертөнцийн Эзэн бусдыг ч Өөртэйгээ эвлэрүүлж, Эцэг нь болж, үнэхээр “бүгдэд бүх юм болох”-ыг бид одоо ч итгэлийн нүдээр хардаг (Колоссай 1:20).




Одоо ч ирээдүйн үнэнд амьдрах нь

Ирээдүйн яруу сайхан тэр үнэнээр бид өнөөдөр ч амьдрахад дуудагдсан юм. Үүний тулд бид харснаараа биш, итгэлээр алхахаас өөр аргагүй. Юм харагдахгүй, хань багатай тэр замаар алхах нь амаргүй юм.

Зүйрлэвээс, бид 1480-аад оны үед нисдэг тэрэгний тухай бодож, далавчит сэнсийг нь зурсан Леонардо да Винчи шиг цагаасаа өмнө явж байгаа. Үнэндээ бид цагаасаа холын хол өмнө явж байгаа хүмүүс.

Есүсийн тунхагладаг байсан хаант улсын тухай сайн мэдээнд итгээд шугаман замаар явдаг итгэгч хүмүүс өнөөгийн эон үеийн төгсгөлийг л харж хүлээдэг. Иймд тэд эон үеүдийн төгсгөлүүд ирсэн тухай Паулын тунхагласан мэдээг сайн ойлгодоггүйд гайхах юмгүй. Тэр сайн мэдээг дагаж, эон үеүдийн төгсгөлүүдийн үнэнд амьдардаг биднийг ч ойлгохгүй байх нь аргагүй.



Израил өнөөгийн эон үеийн төгсгөлийг хардаг

Шугаман замаар явдаг Израилынхны хардаг эон үеийн төгсгөл бол “одоогийн ёрын муу” эон үеийнх (Галат 1:5). Өнөөгийн эон үеийн төгсгөлийн өмнөхөн энэ дэлхийнхэн Ертөнцийн Эзэний ард түмний итгэгч нарыг хавчиж, устгахыг оролдох болно (Илчлэл 6:9-11; 13:7,15; 20:4). Үүнд Ертөнцийн Эзэн хилэгнэн, уур хилэнгээ «Илчлэл»



номд бичсэнчлэн ард түмнийхээ дайснууд дээр асгах болно. Энэ үеийн төгсгөлийн тухай дагалдагч нар нь Есүсээс асуухад Тэр хариуд нь: “Та нар дайн ба дайны сураг чимээг сонсоно. Бүү цочирд. Тэдгээр нь болох учиртай боловч төгсгөл (G5056) нь хараахан биш юм... эцсийг (G5056) хүртэл тэвчсэн нь аврагдах болно” гэж анхааруулсан (Матай 24:3,6,13).



Эцэс төгсгөлд нь Есүс Христ эргэн ирж, дайснуудаа дарж, Хаант улсаа байгуулах болно. Энэхүү төгсгөл Ертөнцийн Эзний хавчигдаж буй ард түмний хувьд үнэхээр аврал болно. Есүсийг буцаж ирэхийг үзүүлсэн үзэгдэлд нэгэн дуу хоолой “Бурханы маань аврал, хүч, хаанчлал ба Түүний Христийн эрх мэдэл ирлээ” гэж хэлсэн нь тийм учиртай (Илчлэл 12:10).

Петрийн хэлснээр: “Есүс Христийн илчлэл дээр... та нар итгэлийнхээ үр дүнд [грек: төгсгөлд, G5056] сэтгэлийн авралыг олж авч байна” гэжээ (1 Петр 1:9).⁴

Петр өөрийн хүмүүстээ “Бүх юмсын төгсгөл (G5056) ойр ирчхээд байна. Тиймээс бодлоготой, залбиралдаа эрүүл

4 “Сэтгэлийн аврал” гэдэг нь Хаант улсад орж, жаргалыг нь амсаж эдлэхийг хэлнэ. Хүн сэтгэлээрээ сэхээтэй байж, юм мэдэрдэг учраас тэр. “Хүн бол амьд сэтгэл” гэдэг нийтлэлийг маань үзнэ үү.



байгтун...” гэж бичиж захиснаас харахад Петр ч гэсэн өөрийн дуудлагынхаа ёсоор голдуу өнөө үеийн төгсгөлийг харж байсан (1 Петр 4:7).

Харин Христийн Биеийнхний хувьд одоогийн эон үеийн төгсгөлийг харж хүлээх шаардлага байхгүй. Ертөнцийн Эзэн уур хилэнгээ буулган дэлхийн хаант улсуудыг үгүй хийх нь дайн мэт. Ямар ч улс орон дайн зарлахаасаа өмнө эхлээд харийн газарт буй элчин сайд нараа заавал татдаг. Бид эвлэрлийг тунхагладаг Христийн элчин сайд нар мөн (2 Коринт 5:20) бөгөөд Ертөнцийн Эзэн эвлэрлийг хүлээж аваагүй хүн төрөлхтөний эсрэг дайтаж эхлэхдээ тэр үүргээ биелүүлэх газаргүй болно. Улмаар, Ертөнцийн Эзэн биднийг “уур хилэнд зориулаагүй” (1 Тесалоник 5:9). Тэгвэл Их Эзэн уур хилэнгээ буулгахаас наана Биеийнхээ гишүүдийг Өөртөө шүүрч авна (1 Тесалоник 1:10, 4:14-17; Ром 5:9). Тэр биднийг “одоогийн ёрын муу үеэс” төгсөхөөс нь ч өмнө чөлөөлөн гаргах болно (Галат 1:4). Түүнтэй уулзах мөчөөс эхлэн бид үхэшгүй амь дүүрэн шинэ биетэй болоход “эон үеүдийн төгсгөлүүд бидэнд хүрч ирсэн” гэсэн үг бүрэн биелэгдэх болно. Тэр өдөр заавал тохиолдох ёстой учраас Их Эзэн биднийг Өөрөө “төгсгөл (G5056) хүртэл батжуулна” (1 Коринт 1:8). Иймд аврал маань эцэс хүртэл тэвчсэн байхаас шалтгаалахгүй.

Израил энэ эоний төгсгөл хүртэхийг найдаж байна

Шугаман замаар явдаг израилынхан өнөөгийн эон үеийн төгсгөлийг хараад зогсохгүй, төгсгөлийг нь хүртэхийг найдаж байна. Үүнийг Паул Херод хааны ач Агрипп



хааны өмнө
зогсохдоо
дурдсан.
Агрийп
иудейчүүдийн
хааны хувьд
мэдээж Израилд
өгсөн
Ертөнцийн
Эзэний
амлалтуудын
тухай мэддэг.



Иймд хаан өөрийг нь **өмгөөлөлтөө хийхээр уриалахад** Паул Ертөнцийн Эзэний эрт дээр үед өгсөн амлалтанд итгэлтэй еврей хүний байр суурийг эзэлсэн. Тухайлбал: “Би одоо манай эцэг өвгөдөд Бурханы өгсөн амлалтын найдвараас болж шүүгдэж байна. Энэ нь манай арван хоёр овог Бурханд өдөр шөнөгүй зүтгэн үйлчилж, хүртэхийг найддаг тэрхүү амлалт мөн” гэжээ (Үйлс 26:6-7).

Өөрөөр хэлбэл, Израилын үнэнч итгэгчид Ертөнцийн Эзэний “өгсөн амлалт” бүрэн биелэх өнөөгийн эон үеийн төгсгөлд “хүртэхийг найддаг” юм.

Сонирхолтой нь, “хүртэх” (G2658) гэж энд орчуулсан үг “эон үеүдийн төгсгөлүүд бидэнд хүрч ирсэн (G2658)” гэсэн үгтэй адил (1 Коринт 10:11). Израилчууд Ертөнцийн Эзэний амлалтын биелэлд хүрэхийг найддаг. Тэд амлагдсан Хаант улсад хүрч орох гэж зүтгэж байна. Харин Христийн Биед хамрагдах бид Ертөнцийн Эзэний амлалтуудын тухай мэдээгүй байхад, хүртэх гэж хичээгээ



ч үгүй байхад амлалтуудынх нь биелэл аль хэдийн бидэнд сүнсээр хүрч ирсэн бөгөөд удахгүй – энэ эон үе төгсөхөөс ч өмнө – бүрмөсөн хүрч ирнэ! Бид “Христэд анх түрүүнд найдсан”-аас илүү “Христийн дотор өмнөх %түрүүлж бүтэх найдлагатай” хүмүүс (Эфэс 1:12, АБ ба МО). Паул Агиппа хаанд дээрх үгээ хэлэхдээ өөрийгөө израилынхан шиг Ертөнцийн Эзэнд итгэлтэй гэж хэлсэн ч тэдэн шиг зүтгэж байгаа гэж хэлээгүйг анхаараарай.

Паулын тунхагласан сайн мэдээ үнэхээр “хүний дагуу биш” болох нь (Галат 1:11) улам ил болж байна. Хүний дагуу байсан бол алхам алхмаар явах шугаман замыг заах байсан. Гэтэл Их Эзэн биднийг Израилын даван туулах олон алхмын дээгүүр харайлган нисүүлж, холын ирээдүйн сайн сайхан үнэнд өнөөдөр ч амьдран жаргаж байхыг хүсдэг. Үгээр хэлшгүй юутай сайхан бэ! Гэхдээ бас ойлгоход юутай хэцүү юм бэ! □



Христтэй нягт холбоотой гишүүд нь “ариун хүмүүс”-т тооцогддог учраас үүнд таарсан амьдралаар замнавал зохино. Дараагийн нийтлэлд Христийн Биеийн гишүүн хэрхэн Загалмайн тухай үгийн дагуу амьдрахыг авч үзнэ.



Ашигласан эх сурвалж:

---Ариун Библи (2004; 2013; 2019). Улаанбаатар: Ариун Бичвэр Нийгэмлэг. Энэ судалгаанд АБ гэж товчилсон. Өөрөөр тодорхойлоогүй бол «Шинэ гэрээ»-ний ишлэлийг энэ орчуулгаас авсан байх болно.

---Barnes, A. (1870). *Albert Barnes' Notes on the Bible*. As found in the [MySword Bible study software program](#)

---Библи (2015). Улаанбаатар : Монголын Библийн Нийгэмлэг. Энэ судалгаанд ББ гэж товчилсон.

---Gill, J. (1746248). *An Exposition of the New Testament*.

<https://www.christianity.com/bible/commentary/john-gill/>

---Стандарт Монгол Орчуулгын апп (2023). Энэ судалгаанд СМО гэж товчилсон. Өөрөөр тодорхойлоогүй бол «Хуучин гэрээ»-ний ишлэлийг энэ орчуулгаас авсан байх болно.

---Strong, J. (1890). *Strong's exhaustive concordance of the Bible (with Greek and Hebrew Lexicons)*. www.blueletterbible.org